

**“СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2016 ОНЫ ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД ТЕХНИК ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААР ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2016 оны 08 дугаар  
сарын 25-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Сумъяабазар**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүдээ,

“Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх саналаа Сонгуулийн ерөнхий хорооноос 2016 оны 08 дугаар сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороо 2016 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 6 дугаар зүйлд сонгуулийн автоматжуулсан системийг сонгуульд хэрэглэх, ашиглах талаарх шийдвэрийг Улсын Их Хурал гаргаж байхаар хуульчилж өгсөн.

Байнгын хорооны хуралдааны үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, саналаа илэрхийлж байсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан 2016 оны Улсын Их Хурлын сонгуулийн үеэр сонгогчдын бүртгэлтэй холбоотой олон маргаан гарч байсан, санал тоолох машинд сонгогчид болон эрх баригчдын зүгээс итгэх итгэл бага байсан зэргийг харгалзан энэ талаар цаашид ажлын хэсэг байгуулж судлах нь зүйтэй гэсэн саналыг гаргаж байсан болно.


Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд “Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэж санал нэгтэйгээр дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



**Н.ЭНХБОЛД**

Төсөл

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2016 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар  
хот

**Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын 2016 оны ээлжит сонгуульд  
техник хэрэгсэл хэрэглэх тухай**

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн сонгогчдын бүртгэлийн үйл ажиллагаанд бүртгэлийн техник хэрэгслийг, санал авах, тоолох үйл ажиллагаанд “New Image Cast” санал тоолох төхөөрөмжийг тус тус хэрэглэхийг зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолыг 2016 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг